

## “МОННАБ” ХК

### **Компанийн засаглалын үнэлгээний асуулга**

Кодексийн хэрэгжилтийг “Хэрэгжүүл, эсвэл тайлбарла” гэсэн зарчмын дагуу тайлагнах ба кодексийн зүйл тус бүрээр биелүүлсэн эсэх, биелүүлээгүй бол яагаад биелүүлээгүй, түүнийг орлох бүтэц, зохион байгуулалтын арга хэмжээ авсан, эсхүл авч байгаа, хэрэв төлөвлөж буй бол хугацаатайгаар нь тайлбар хэсэгт тусгана..

### **НЭГ. ТУЗ-ИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

**ТУЗ нь олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал зэргийг зохистойгоор хангасан, алсын хараатай, бүтээлч, үр дүнтэй бүтэц байна**

№	Зүйл	Хэрэгжилт	Тайлбар	Оноо	Хувь
1	<b>1.1. Компани нь ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын чиг үүрэг, хариуцлагыг нарийвчлан зохицуулна.</b>	ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар зохицуулдаг.			
2	<b>1.2. Компани нь ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, томилох асуудлыг тусгасан нэр дэвшүүлэх журам, залгамж халааны бодлогын баримттай байна.</b>	ТУЗ-ийн нэр дэвшүүлэх хорооны дүрэм, Залгамж халааны бодлогын баримт бичигтэй.			
3	<b>1.3. ТУЗ-ийн гишүүн бүрийн ажлын туршилага, ажилласан хугацаа, хараат бус байдал, хувьцааны эзэмшилийн хувь хэмжээ, хуралдаанд оролцсон ирц зэрэг мэдээллийг жилийн үйл ажиллагааны тайланд дэлгэрэнгүйгээр тусгаже, цахим хуудсандaa байришуулна.</b>		2022 оны жилийн үйл ажиллагааны тайланд мэдээллийг бүрэн тусгана.		
4	<b>1.4. Компани нь ТУЗ болон түүний дэргэдэх хороодын бүтэц, бүрэлдэхүүний бодлогын баримттай байх ба уг баримт бичигт гишүүний боловсрол, мэргэшил, ур чадвар, туршилагад тавигдах шаардлага болон хүйсийн тэнцвэрт байдал зэргийг тусгана.</b>	ТУЗ болон ТУЗ-ийн дэргэдэх хороодын дүрэмтэй.			
5	<b>1.5. ТУЗ-ийн гишүүнийг анх томилогоход чиглүүлэх сургалтыг зохион байгуулах ба ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ур чадвар, мэдлэг, мэдээллийг олгох, тэдгээрийг шинэчлэх сургалтад тогтмол хамруулна.</b>	ТУЗ-ийн шинэ гишүүнийг шаардлагатай мэдээлээр хангадаг.			

6	<b>1.6. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн үйл ажиллагааг зохицтой явуулах асуудлаар ТУЗ-ийн даргаар дамжуулан хариуцлага хүлээнэ.</b>	ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар зохицуулдаг.			
---	---	--	--	--	--

ДҮН

### ХОЁР. ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД, ТЭДГЭЭРИЙН ЧИГ ҮҮРЭГ

**ТУЗ нь өөрийн үйл ажиллагааг тодорхой чиг үүрэг хариуцсан өөрийн дэргэдэх хороодоор дамжуулан хэрэгжүүлж, эцсийн хариуцлагыг хүлээнэ**

7	<b>2.1. ТУЗ-ийн дарга болоод ТУЗ-ийн гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байхыг зорино.</b>	ТУЗ -н гишүүдийн 1/3 нь хараат бус гишүүд байгаа			
8	<b>2.2. ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо нь үйл ажиллагааны журам аудитын бодлогын баримт бичигтэй байна. Аудитын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус байна. Аудитын хорооны хуралд компанийн гүйцэтгэх удирдлага болон ажилтнууд гагцхүү тус хорооны хүсэлтээр оролцно.</b>	Аудитын хорооны үйл ажиллагааны журамтай.  Аудитын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга биш, хараат бус гишүүн .			
9	<b>2.3. ТУЗ-ийн дэргэдэх цалин урамшууллын хороо нь цалин, урамшууллын үйл ажиллагааны журам, цалин урамшууллын бодлогын баримт бичигтэй байна. Цалин урамшууллын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна. Цалин урамшууллын хорооны хуралд гүйцэтгэх удирдлага гагцхүү хорооны хүсэлтээр оролцно.</b>	Цалин ухамшууллын хорооны үйл ажиллагааны журамтай.  Хорооны дарга нь ТУЗ-ийн дарга биш, хараат бус гишүүн			
10	<b>2.4. ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороо нь үйл ажиллагааны журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна. Нэр дэвшүүлэх хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна.</b>	Нэр дэвшүүлэх хорооны үйл ажиллагааны журамтай.  Хорооны дарга нь ТУЗ-ийн дарга биш, хараат бус гишүүн.			
11	<b>2.5. ТУЗ нь өөрийн дэргэд бусад чиг үүрэг бүхий байнгын болон түр хороог байгуулж болно. ТУЗ-ийн дэргэдэх хороод бүгд үйл ажиллагааны журам, заавартай, чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур</b>		Шаардлагатай үед нь түр хороо байгуулж болно.		

	чадвар, ажлын түриллага бүхий бүрэлдэхүүнтэй байна.			
--	---	--	--	--

ДҮН

### ГУРАВ. ТАЙЛАГНАЛ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ

ТУЗ нь санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал, мэдээллийн ил тод байдлын үнэн, бүрэн, тэнцвэрт байдлыг хангана

12	3.1. ТУЗ нь компанийн мэдээллийн ил тод байдал, тайлagnалын журмыг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	биелүүлсэн		
13	3.2. ТУЗ нь энэхүү кодекст заасан засаглалын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд хүргэнэ.		Арга хэмжээ авч ажиллана.	
14	3.3. Санхүүгийн болон санхүүгийн бус тайлан нь тэнцвэртэй, тодорхой, бодит байна. Санхүүгийн бус тайлан нь хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засгийн хүрээнд компанийн тогтвортой үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй хүчин зүйлс, эрсдэл, компанийн үйл ажиллагааны зорилго, зорилтууддаа хүрсэн эсэхийг үнэлсэн мэдээлэл байна.		Шаардлагатай үед нь	

ДҮН

### ДӨРӨВ. АУДИТ, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО

ТУЗ нь аудит, хяналтын тогтолцооны хараат бус, үр дүнтэй байдлыг хангана

15	4.1. ТУЗ нь аудитын хорооны үйл ажиллагааны журамд хөндлөнгийн аудитортой харьцах, түүнийг хуульд заасан чиг үүргээ саадгүй гүйцэтгэх нөхцөл боломжсоор хангах талаар тусгаж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	Аудитын байгууллага-тай гэрээтэй ажилладаг		
16	4.2. Хөндлөнгийн аудитор нь хувьцаа эзэмшигчдийн ээлжсит хуралд оролцож, аудиттай холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгдөг байна.		2023 оны ХЭХурлаас оролцуулна	

17	<i>4.3. Дотоод аудитын тогтолцоо, түүний бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, тэдгээрт орсон өөрчлөлтийн талаарх мэдээллийг компанийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар олон нийтэд тухай бүр мэдээлнэ.</i>		2022 оны жилийн үйл ажиллагааны тайлангаар болон өөрчлөлт орсон тухай бүрд цахим хуудсаар дамжуулан мэдээлнэ.	
----	---	--	---	--

ДҮН

#### **ТАВ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА**

**ТУЗ нь эрсдэлийн удирдлага болон комплайнсын хяналтыг зохистой байдлаар, хараат бусаар зохион байгуулж, тэдгээрийн үр дүнтэй байдалд тогтмол хяналт тавина**

18	<i>5.1. Компани нь эрсдэлийн удирдлагын заавар болон бүтэцтэй байх ба эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина.</i>	Дотоод хяналтаар зохицуулдаг.		
19	<i>5.2. ТУЗ нь дэргэдээ эрсдэлийн удирдлага хариуцсан хороотой байхыг зорих ба уг хороо нь гурваас доошигүй тооны гишүүнтэй, дарга болон гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байна. Эредэлийн хорооны үйл ажиллагааны журам, бүтэц, бүрэлдэхүүнийг компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлж, тус хорооны хурлын ири, хуралдсан асуудал, давтамжийн талаар тогтмол тайлagnана.</i>		2022 оны жилийн үйл ажиллагааны тайландаа тусгана.	
20	<i>5.3. Компанийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл байгаа эсэхийг үнэлэн нийтэд мэдээлж, тэдгээр эрсдэлийг хэрхэн удирдааж буйгаа тайлбарлана.</i>		2022 оны жилийн үйл ажиллагааны тайландаа тусгана.	
21	<i>5.4. Компани нь комплайнсын хяналтын заавар болон бүтэцтэй байх ба комплайнсын хяналтын хэрэгжилтийн үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина.</i>		2022 оны жилийн үйл ажиллагааны тайландаа тусгана.	

ДҮН		
-----	--	--

### **ЗУРГАА. ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ЦАЛИН УРАМШУУЛАЛ**

**Эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ нь компанийн алсын хараа, онцлогт тохирсон, шударга, ил тод байна**

22	<b>6.1. ТУЗ-ийн гишүүний цалин, урамшууллын хэмжээ, олгох хэлбэр, давтамжийг хувьцаа эзэмшигчийн хурлаар ил тод хэлэлцэж батална.</b>	ТУЗ-ийн гишүүдэд цалин урамшуулал олгодоггүй		
23	<b>6.2. Компани цалин, урамшууллын хэмжээг тогтоох үндэслэл болсон ажил үүргийн бүрдэл хэсгүүд, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг цалин, урамшууллын бодлогын баримтад тусгана.</b>		цалин, урамшууллын бодлогын баримтад тусгана.	
24	<b>6.3. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд гүйцэтгэх удирдлагын үндсэн цалин, шагнал бусад урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуурыг тусгана.</b>		цалин, урамшууллын бодлогын баримтад тусгана.	

ДҮН		
-----	--	--

### **ДОЛОО. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ АШИГ**

**Компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх ашгийг хүндэлнэ**

25	<b>7.1. Компани нь ТУЗ-өөс баталсан бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах талаар бодлогын баримт бичигтэй байна. ТУЗ болон гүйцэтгэх удирдлага нь оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, тэдэнтэй хамтран ажиллах байгууллагын соёлыг төлөвшүүлнэ.</b>		2022-4 р улиралд багтаан бодлогын баримт боловсруулж мөрдөнө	
26	<b>7.2. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд оролцогч талуудтай хамтран ажиллахдаа ямар асуудалд голчлон анхаарч, ямар стратеги баримтлан хэрхэн хэрэгжүүлжээ ажилласан талаар тусгана.</b>		бодлогын баримтад тусгана	
27	<b>7.3. Оролцогч талуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, харилцах зорилгоор</b>			

	<i>компанийн цахим хуудсыг үр дүнтэйгээр ажиллуулна.</i>		Цахим хуудсыг үр дүнтэй ажиллуулна.	
28	<i>7.4. Компанийн ажилтнуудын санал, хүсэлт, гомдолыг хүлээн авч шийдвэрлэх дотоод журам, нийгмийн асуудлыг шийдэх, мэргэжил дэшилүүлэх дотоод журам, ажлын төлөвлөгөөтэй байна.</i>	Дотоод журамд байгаа		

ДҮН

**НАЙМ. КОМПАНИЙН СОЁЛ**

**ТУЗ-ийн гишүүд компанийд бизнесийн ёс зүйн өндөр хэм хэмжээг тогтоож, өөрсдөө манлайлан гүйцэтгэх удирдлага, ажилтнуудад мөрдлөг болгоно**

29	<i>8.1. Компанийн үнэт зүйлс, алсын харааг оновчтой тодорхойлж, хууль ёсны, ёс зүйтэй, хариуцлагатай үйл ажиллагаа явуулах зорилгоор ТУЗ нь ёс зүйн дүрмийг батлан, нийтэд мэдээлжс, хэрэгжилтэд нь хяналт тавина.</i>		2022-4 р улиралд багтаан ёс зүйн дүрэм боловсруулж мөрдөнө	
30	<i>8.2. Аливаа хууль бус үйлдэл болон ёс зүйн зөрчлийг ТУЗ, эсвэл түүний дэргэдэх холбогдох хороонд мэдээлэх “шүгэл үзээгчийн” тогтолцоотой байна.</i>		ёс зүйн дүрэмд тусгаж мөрдөнө	
31	<i>8.3. Ёс зүйн дүрмээр авлига, албан тушаалын гэмт хэрээс ангид байх болон улс төрийн үйл ажиллагааг дэмжих, /дэмжихгүй байх/ хандив өргөх /өргөхгүй байх/ талаар зохицуулна.</i>		ёс зүйн дүрмээр зохицуулна.	

ДҮН

**ЕС. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ**

**Компани болон ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн эрхийг хүндэтгэн тэгш хандаж, мэдээлэл авах болон эрхээ хэрэгжүүлэх бололцоогоор бүрэн хангана**

32	<i>9.1. Компани оролцогч талуудад өөрийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, засаглалын бүтэц, зохион байгуулалт, гүйцэтгэлийн үр</i>			
----	---	--	--	--

	<i>дүнгийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа тухай бүр хүргэнэ.</i>	цахим хуудсаар дамжуулан мэдээлэл хүргэдэг.			
33	<i>9.2. Компани хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөртэй байх ба тэдэнтэй харилцах, мэдээлэл солилцох цахим сувгийг хөгжүүлнэ.</i>		цахим хуудсаар дамжуулан мэдээлэл хүргэх хөрөнгө оруулагч цэс тэй болно		
34	<i>9.3. Компани хувьцаа эзэмшигчийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, санал гаргах, санал өгөх, мэдээлэл авах зэрэг хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх бололцоо, нөхцөлийг бүрдүүлнэ.</i>	Хувьцаа эзэмшигчид хууль ёсны эрхээ эдлэх нөхцөл, бүх талынболомжтой.			
35	<i>9.4. Компанийн үйл ажиллагааны чиглэл, өмчлөлийн бүтцийн асуудлаар хувьцаа эзэмшигчдээс санал өгөх эрхээ хэрэгжүүлэхэд нь онцгойлон анхаарна.</i>		хувьцаа эзэмшигчдээс санал өгөх эрхээ хэрэгжүүлэхэд нь онцгойлон анхаарна.		
36	<i>9.5. Компани болон хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлэх зорилгоор сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журамтай байх ба хэрэгжилтийг нийтэд мэдээлнэ.</i>		Дотоод журамд байгаа		
ДҮН					
<b>НЭГДСЭН ДҮН</b>					

-Оо-